

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Рашаант сумын эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2026/021/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Мөрөн сум

2026 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо

Утас:88688168 Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа

Утас:99389208 Цахим хаяг: b_myadagmaa@yahoo.com

Аудитор Ц.Мөнхтуяа

Утас: 99382220 Цахим хаяг: Munkhtuya2220@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А хороус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793. Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 01/170
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН РАШААНТ
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Б.САРУУЛ ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Рашаант сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Рашаант сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сангаас авах 142,374.1 мянган төгрөгийн санхүүжилтийн авлагатай, төсөвт хасах тодотгол хийснээс шалтгаалан байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын 18,753.2 мянган төгрөгийн өр төлбөртэй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар 21,690.4 мянган төгрөгийн 8 алдаа, зөрчлийг илрүүлж 13,111.7 мянган төгрөгийн 7 алдааг залруулж, 8,578.7 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж хүргүүллээ.

Бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Рашаант сумын Эрүүл мэндийн төвтэй байгуулсан анхан шатны тусламж үйлчилгээг худалдан авах 2025 оны гэрээний биелэлтийг 91.0 хувьтай дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А. ЭРДЭНЭБААТАР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	386,722,636.55	409,367,474.49
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	33,147,662.73	94,484,295.29
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	33,147,662.73	94,484,295.29
3121	Төгрөг	33,147,662.73	94,484,295.29
31211	Төрийн сангийн харилцах	33,147,662.73	94,484,295.29
33	АВЛАГА	216,260,715.07	142,374,072.47
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	216,260,715.07	142,374,072.47
35	БАРАА МАТЕРИАЛ	137,314,258.75	172,509,106.73
351	Түүхий эд материал	39,263,117.11	55,333,752.59
35130	Эм боох материал	39,263,117.11	55,333,752.59
354	Хангамжийн материал	98,051,141.64	117,175,354.14
35410	Бичиг хэргийн материал	2,176,050.00	2,561,610.00
35420	Аж ахуйн материал	00.00	11,950,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	5,050,000.00
35460	Хүнсний материал	3,186,407.50	4,078,110.00
35470	Бусад хангамжийн материал	92,688,684.14	93,535,634.14
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	574,531,099.95	556,135,034.61
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	574,531,099.95	556,135,034.61
392	Биет хөрөнгө	562,677,099.95	544,281,034.61
39201	Барилга, байгууламж, орон сууц	368,379,129.00	368,379,129.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-58,660,644.91	-70,121,014.75
39203	Авто-тээврийн хэрэгсэл	86,484,000.00	86,484,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-6,444,500.07	-20,858,500.11
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	199,822,662.06	236,912,662.06
39206	Хуримтлагдсан элэгдэл	-59,616,104.00	-88,694,969.03
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38,084,682.00	44,179,682.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,579,207.22	-14,457,037.57
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,000,000.00	14,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-9,792,916.91	-11,542,916.99
393	Биет бус хөрөнгө	11,854,000.00	11,854,000.00
39301	Програм хангамж	407,500.00	407,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-407,500.00	-407,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	11,854,000.00	11,854,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	961,253,736.50	965,502,509.10
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	28,772,461.58	23,008,233.34
413	Өглөг	28,772,461.58	23,008,233.34
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,676,324.22	00.72
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	12,689,937.36	18,753,232.62
4136	Бусад өглөг	14,406,200.00	4,255,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	14,406,200.00	4,255,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	932,481,274.92	942,494,275.76
51	Засгийн газрын хувь оролцоо	932,481,274.92	942,494,275.76
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	243,416,874.00	243,416,874.00
51101	Өмч: - төрийн	243,416,874.00	243,416,874.00
512	Хуримтлагдсан үр дүн	429,370,725.26	439,383,726.10
51210	Өмнөх үеийн үр дүн	429,370,725.26	429,370,725.26
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	10,013,000.84
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	259,693,675.66	259,693,675.66
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	961,253,736.50	965,502,509.10

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,211,693,424.85	1,340,813,851.66
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	191,451,921.10	117,902,856.46
120	Нийтлэг татварын бус орлого	191,451,921.10	117,902,856.46
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	191,451,921.10	117,902,856.46
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	46,664,000.00	77,749,123.76
1200017	Үнэ төлбөргүй хүлээж авсан орлого-үндсэн хөрөнгө	118,243,060.00	19,700,000.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээж авсан орлого-бараа материал	26,544,861.10	20,453,732.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,020,241,503.75	1,222,910,995.20
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	39,640,700.00	31,372,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	39,640,700.00	31,372,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	980,600,803.75	1,191,538,695.20
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	980,600,803.75	1,191,538,695.20
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,074,069,720.31	1,330,800,850.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,074,069,720.31	1,330,800,850.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,027,545,720.31	1,256,505,707.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	690,438,734.14	809,370,413.00
210101	Үндсэн цалин	399,395,473.90	477,085,363.90
210102	Нэмэгдэл	231,962,939.88	259,463,908.09
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,396,000.00	39,871,160.00
210104	Урамшуулал	50,684,320.36	32,949,981.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,770,625.23	115,134,076.50
210201	Тэтгэврийн даатгал	61,378,231.81	77,251,876.50
210202	Тэтгэмжийн даатгал	6,699,634.59	9,470,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,322,336.20	4,735,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,333,143.88	4,735,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,037,278.75	18,941,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,408,387.36	34,723,945.26
210301	Гэрэл, цахилгаан	3,049,740.96	3,299,082.68
210302	Түлш, халаалт	30,958,646.40	30,958,646.40
210303	Цэвэр, бохир ус	2,400,000.00	466,216.18
2104	Хангамж, бараа материалын зардал	44,734,550.00	58,544,453.05
210401	Бичиг хэрэг	5,218,700.00	6,723,440.00
210402	Тээвэр, шатахуун	29,021,850.00	23,618,390.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,179,600.00	3,828,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	10,140,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,314,400.00	9,401,350.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	4,833,273.05
2105	Нормативт зардал	113,658,608.65	101,900,241.97
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	98,367,408.65	82,854,344.47
210502	Хоол, хүнс	15,291,200.00	19,045,897.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,410,000.00	35,985,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	3,435,000.00
210604	Урсгал засвар	6,410,000.00	32,550,000.00
2107	Томиллолт, зочны зардал	3,474,000.00	5,968,000.00
210702	Дотоод албан томиллолт	3,474,000.00	5,968,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,333,072.00	33,202,512.05
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,078,000.00	32,098,040.05

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	942,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	24,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	55,510.00	89,210.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	12,000.00	13,400.00
210807	Газрын төлбөр	35,562.00	35,562.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,317,742.93	61,677,065.34
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,896,000.00	96,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	37,421,742.93	61,581,065.34
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,524,000.00	74,295,143.65
2132	Бусад урсгал шилжүүлэг	46,524,000.00	74,295,143.65
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	65,811,143.65
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	46,524,000.00	8,484,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	137,623,704.54	10,013,000.84
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	581,220.00	00.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	581,220.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-581,220.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	137,042,484.54	10,013,000.84

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,068,726,829.75	1,374,546,761.56
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	46,664,000.00	77,749,123.76
120	Нийтлэг татварын бус орлого	46,664,000.00	77,749,123.76
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	46,664,000.00	77,749,123.76
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	46,664,000.00	77,749,123.76
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,022,062,829.75	1,296,797,637.80
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	39,640,700.00	31,372,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	39,640,700.00	31,372,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	982,422,129.75	1,265,425,337.80
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	982,422,129.75	1,265,425,337.80
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,042,963,334.65	1,289,725,129.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,042,963,334.65	1,289,725,129.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	996,439,334.65	1,215,429,985.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	690,424,552.96	809,370,413.00
210101	Үндсэн цалин	396,881,292.72	477,085,363.90
210102	Нэмэгдэл	231,962,939.88	259,463,908.09
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,396,000.00	28,756,980.00
210104	Урамшуулал	53,184,320.36	44,064,161.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,108,482.19	116,810,400.00
210201	Тэтгэврийн даатгал	60,114,400.00	78,928,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,550,995.55	9,470,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,197,487.45	4,735,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,308,199.19	4,735,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,937,400.00	18,941,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,540,700.00	21,352,300.00
210301	Гэрэл, цахилгаан	3,049,740.96	3,299,082.68
210302	Түлш, халаалт	26,090,959.04	17,587,001.14
210303	Цэвэр, бохир ус	2,400,000.00	466,216.18

2104	Хангамж, бараа материалын зардал	49,876,550.00	51,887,690.00
210401	Бичиг хэрэг	4,313,200.00	5,760,000.00
210402	Тээвэр, шатахуун	29,021,850.00	23,618,390.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,016,100.00	3,991,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,462,600.00	8,452,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,062,800.00	10,065,400.00
2105	Нормативт зардал	96,142,577.50	119,766,190.30
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	73,092,077.50	94,006,740.30
210502	Хоол, хүнс	17,340,400.00	14,708,450.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,710,100.00	11,051,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,294,400.00	48,351,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	11,162,100.00
210602	Тавилга	1,993,600.00	2,469,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,950,800.00	3,435,000.00
210604	Урсгал засвар	19,350,000.00	31,284,500.00
2107	Томилолт, зочны зардал	3,474,000.00	5,968,000.00
210702	Дотоод албан томилолт	3,474,000.00	5,968,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,487,072.00	33,202,512.05
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,750,000.00	32,098,040.05
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	480,000.00	942,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	24,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	55,510.00	89,210.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	12,000.00	13,400.00
210807	Газрын төлбөр	35,562.00	35,562.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,154,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,091,000.00	8,720,980.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,091,000.00	8,720,980.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,524,000.00	74,295,143.65
2132	Бусад урсгал шилжүүлэг	46,524,000.00	74,295,143.65
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	65,811,143.65
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	46,524,000.00	8,484,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	25,763,495.10	84,821,632.56
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	22,328,900.00	23,485,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,328,900.00	23,485,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	22,328,900.00	23,485,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	22,328,900.00	23,485,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-22,328,900.00	-23,485,000.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	3,434,595.10	61,336,632.56
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	29,713,067.63	33,147,662.73
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	33,147,662.73	94,484,295.29

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	243,416,874.00	261,437,335.66	90,050,417.65	594,904,627.31
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,743,660.00	1,743,660.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	243,416,874.00	261,437,335.66	91,794,077.65	596,648,287.31
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	137,042,484.54	137,042,484.54
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	243,416,874.00	259,693,675.66	429,370,725.26	932,481,274.92
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	10,013,000.84	10,013,000.84
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	243,416,874.00	259,693,675.66	439,383,726.10	942,494,275.76

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,572,859,300.00	1,343,174,461.56	229,684,838.44	85.40
12	Татварын бус орлого	1,572,859,300.00	1,343,174,461.56	229,684,838.44	85.40
120	Нийтлэг татварын бус орлого	106,988,200.00	77,749,123.76	29,239,076.24	72.67
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	106,988,200.00	77,749,123.76	29,239,076.24	72.67
122	Тусламжийн орлого	1,465,871,100.00	1,265,425,337.80	200,445,762.20	86.33
122001	Хандив тусламж /дотоод/	1,465,871,100.00	1,265,425,337.80	200,445,762.20	86.33
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,606,007,000.00	1,281,837,829.00	324,169,171.00	79.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,606,007,000.00	1,281,837,829.00	324,169,171.00	79.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,606,007,000.00	1,207,542,685.35	398,464,314.65	75.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	930,698,400.00	809,370,413.00	121,327,987.00	86.96
210101	Үндсэн цалин	573,470,400.00	477,085,363.90	96,385,036.10	83.19
210102	Нэмэгдэл	282,186,300.00	259,463,908.09	22,722,391.91	91.95
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,051,200.00	28,756,980.00	5,294,220.00	84.45
210104	Урамшуулал	40,990,500.00	44,064,161.01	(3,073,661.01)	107.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	118,490,500.00	116,810,400.00	1,680,100.00	98.58
210201	Тэтгэврийн даатгал	81,394,100.00	78,928,200.00	2,465,900.00	96.97
210202	Тэтгэмжийн даатгал	8,684,700.00	9,470,500.00	(785,800.00)	109.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,735,300.00	4,735,300.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,735,300.00	4,735,300.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18,941,100.00	18,941,100.00	-	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	57,200,600.00	51,887,690.00	5,312,910.00	90.71
210401	Бичиг хэрэг	6,886,700.00	5,760,000.00	1,126,700.00	83.64
210402	Тээвэр, шатахуун	25,000,000.00	23,618,390.00	1,381,610.00	94.47
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,180,100.00	3,991,500.00	1,381,610.00	94.47
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,068,400.00	8,452,400.00	1,188,600.00	77.05

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,065,400.00	10,065,400.00	1,616,000.00	83.95
2105	Нормативт зардал	141,953,400.00	120,665,190.30	-	100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	102,219,500.00	94,006,740.30	21,288,209.70	85.00
210502	Хоол, хүнс	24,510,900.00	14,708,450.00	8,212,759.70	91.97
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	15,223,000.00	11,950,000.00	9,802,450.00	60.01
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	69,086,600.00	58,317,500.00	3,273,000.00	78.50
210601	Багаж, техник, хэрэгсэл	25,128,000.00	22,431,100.00	10,769,100.00	84.41
210602	Тавилга	6,256,400.00	6,256,400.00	2,696,900.00	89.27
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,663,100.00	3,435,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	33,039,100.00	26,195,000.00	1,228,100.00	73.66
2107	Томилолт, зочны зардал	7,500,000.00	5,968,000.00	6,844,100.00	79.28
210702	Дотоод албан томилолт	7,500,000.00	5,968,000.00	1,532,000.00	79.57
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	159,501,500.00	33,202,512.05	1,532,000.00	79.57
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	155,821,000.00	32,098,040.05	126,298,987.95	20.82
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	942,300.00	123,722,959.95	20.60
210803	Даатгалын үйлчилгээ	66,000.00	24,000.00	209,700.00	81.80
210804	Тээврийн хэрэгслийн татвар	155,600.00	89,210.00	42,000.00	36.36
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	32,900.00	13,400.00	66,390.00	57.33
210807	Газрын төлбөр	120,000.00	35,562.00	19,500.00	40.73
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,154,000.00	00.00	84,438.00	29.64
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,000,000.00	11,320,980.00	2,154,000.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,000,000.00	11,320,980.00	4,679,020.00	70.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	105,576,000.00	74,295,143.65	4,679,020.00	70.76
2132	Бусад урсгал шилжүүлэг	105,576,000.00	74,295,143.65	31,280,856.35	70.37
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	97,092,000.00	65,811,143.65	31,280,856.35	70.37
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,484,000.00	8,484,000.00	31,280,856.35	67.78
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(33,147,700.00)	61,336,632.56		
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	33,147,700.00	(61,336,632.56)		
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	33,147,700.00	(61,336,632.56)		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	33,147,662.73		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	94,484,295.29		

Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	төгрөгөөр	
				Зөрүү	Хувь

1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	31,372,300.00	31,372,300.00	-	100.00
12	Татварын бус орлого	31,372,300.00	31,372,300.00	-	100.00
122	Тусламжийн орлого	31,372,300.00	31,372,300.00	-	100.00
122005	Төсвөөс санхүүжих	31,372,300.00	31,372,300.00	-	100.00
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	31,372,300.00	31,372,300.00	-	100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	31,372,300.00	31,372,300.00	-	100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	21,352,300.00	21,352,300.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,352,300.00	21,352,300.00	-	100.00
210301	Гэрэл, цахилгаан	3,600,000.00	3,600,000.00	-	100.00
210302	Түлш, халаалт	17,425,300.00	17,425,300.00	-	100.00
210303	Цэвэр, бохир ус	327,000.00	327,000.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,020,000.00	10,020,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	10,020,000.00	10,020,000.00	-	100.00
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	-		
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-		
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	-		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-		

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 21,690.4 мянган төгрөгийн 8 алдаа, зөрчлийг илрүүлснээс 13,111.7 мянган төгрөгийн 5 алдааг залруулж, 8,578.7 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгч, нийцлийн аудитаар илэрсэн 2 зөрчилд зөрчил таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

3.1 Залруулсан алдаа

- Тус эрүүл мэндийн төв нь 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг бэлтгэж ирүүлэхдээ тайлант жилийн худалдан авах ажиллагааны тайланг бэлтгэж ирүүлээгүй, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн маягтын дагуу бэлтгээгүй нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.3 “тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл;” заалттай нийцэхгүй байх тул аудитын явцад нөхөн гаргасан.
- Нийгмийн эрүүл мэндийн зардлаас бэлтгэсэн 6,022.2 мянган төгрөгийн хоол хүнс, бичиг хэргийн бараа материалыг үр дүнгийн тайланд бусад зардлаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.1 “үнэн зөв байх” заалттай нийцэхгүй “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул холбогдох зардлын данс уруу залруулга бичилт хийсэн.
- Жилийн эцэст орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн 844.0 мянган төгрөгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд тохируулах бичилт хийгээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7 “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах;” заалттай нийцэхгүй “толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад тохируулгыг хийж, төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөвөөр тайлагнасан.
- Ашиглалтын шаардлага хангахгүй акталсан 4,833.3 мянган төгрөгийн бараа материалыг тайлант үеийн зардлаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай

хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” заалттай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад залруулсан.

- Аймгийн Эрүүл мэндийн газраас орж ирсэн орлогыг төрийн сангийн цахим удирдлагын системд ЭМДС-ийн санхүүжилтээр бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” заалттай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад залруулсан.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 8,578.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 17,185.1 мянган төгрөгөөс 8,606.4 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

3.2. Албан шаардлага

1. Шилэн дансны цахим хуудсанд төсвийн байгууллагын батлагдсан төсвийн мэдээлэл, санхүүгийн тайлан, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан болон 5 сая төгрөгөөр дээш үнийн дүн бүхий орлогын 23, зарлагын 10 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн нь өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;”, 6 дугаар зүйлийн 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;” гэж заасан заалттай нийцэхгүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байгаа нь “нийцсэн бөгөөд зохистой” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Иймд зөрчил таслан зогсоох тухай албан шаардлагыг хүргүүлсэн.
2. Рашаант сумын эрүүл мэндийн төв нь 2025 онд цахим дэлгүүрээс худалдан авах боломжтой 13,666.1 мянган төгрөгийн эмийг шууд худалдан авсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 “Энэ хуулийн 37.2.4-т тодорхойлсон захиалагч ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна.” заалттай нийцэхгүй “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул зөрчил таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

3.3. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт1:

Байгууллагын шилдэг ажилтны шагналд 2,804.8 мянган төгрөгийг цалингийн зардлаас гаргаж эдийн засгийн ангилал зөрчсөн нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;” заалттай нийцэхгүй “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Илрүүлэлт2:

Ажил олгогчоос олгох нийгмийн даатгалын шимтгэл, цалингийн бүлэг хооронд 5,773.9 мянган төгрөгийн гүйлгээг эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 заалтад заасан “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;” заалттай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийг батлагдсан эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж байх

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
							Залруулсан		Залруу лаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланг батлагдсан маягтаар бэлтгээгүй, худалдан авах ажиллагааны тайланг дутуу ирүүлсэн.	1	-	1	-			1	-		
Төсвийн гүйцэтгэлийн тохируулга хийгээгүй	1	844.0			1	844.0	1	844.0		
ЭМГ-аас орж ирсэн орлогыг төрийн сангийн системд буруу залруулсан	1	1,412.2			1	1,412.2	1	1,412.2		
Акталсан бараа материалыг тайлант үеийн зардлаар бүртгэсэн	1	4,833.3			1	4,833.3	1	4,833.3		
НЭМ-ийн зардлаас зарцуулсан эм, хүнс, бичиг хэргийн зардлыг холбогдох зардалд нь бүртгээгүй, бусад зардлаар бүртгэсэн	1	6,022.2			1	6,022.2	1	6,022.2		
Дүн	5	13,111.7	1	-	4	13,111.7	5	13,111.7		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийсэн.	1	8,578.7					1	8,578.7
Дүн	1	8,578.7					1	8,578.7

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цахим дэлгүүрээс худалдан авах боломжтой эмийг шууд худалдан авалт хийсэн.	1	-			1	-		
Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл хоцроож оруулсан, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй	1	-			1	-		
Дүн	2	-			2	-		

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			